

БАТЛАВ,  
"ПЕТРОСТАР" ХХК-ийн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.Байгалтуяа

БАТЛАВ, ТӨЛӨӨТ  
"РАДИО Т.Ү. С" УТҮГ

ЗАХИРАЛ

С.Цагаанхүү

### ШАТАХУУНЫ КАРТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2021 оны 5-р сарын 19-ны өдөр

№ 808

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "Петростар ХХК РД: 5241901, УБД: 9011160034" -ыг төлөөлж Картын ахлах менежер Б.Энхтуяа (цаашид "Картаар үйлчлэгч" гэх), нөгөө талаас "Радио Телевизийн Үндэсний Сүлжээ" УТҮГ РД:5021111, УБД:.....-ыг төлөөлж Хангамжийн хэлтсийн дарга ажилтай Э.Энхгэрэл (цаашид "Карт эзэмшигч" гэх) (цаашид дангаар нь "Тал", хамтад нь "Талууд" гэх) нар Монгол Улсын Иргэний хуульд нийцүүлэн энэхүү гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Картаар үйлчлэгч нь Улаанбаатар хот дахь өөрийн шатахуун түгээх станцууд болон зэргэлдээ компани болох НИК ХХК-ийн хөдөө, орон нутагт байрлах шатахуун түгээх станцууд (цаашид "ШТС" гэх)-аас шатахуун авах эрх бүхий картыг Карт эзэмшигчид олгох, Карт эзэмшигч картаа хүлээн авч ашиглахтай холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү гэрээ нь хүсэл зориггоо бүрэн илэрхийлж, сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд талууд гэрээний зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн уншиж танилцан, гарын үсэг зурж хүлээн зөвшөөрсөн болно.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ, ТӨЛБӨР ТООЦОО

- 2.1. Карт ашиглах ерөнхий нөхцөлийг нийтэд зарласны дагуу Картаар үйлчлэгч тогтооно.
- 2.2. Карт эзэмшигч энэхүү гэрээ байгуулснаар карт эзэмших эрх үүснэ.
- 2.3. Карт эзэмшигч нь Картаар үйлчлэгчийн банк дахь харилцах дансанд өөрийн эзэмшлийн картыг цэнэглэх мөнгөн дүнг урьдчилан шилжүүлснээр картыг ашиглах буюу ШТС-уудаас шатахуун авах боломжтой болно.
- 2.4. Картаар үйлчлэгч нь Карт эзэмшигчийн байршуулсан мөнгөнд хүү тооцохгүйгээр ШТС-уудаас тухайн үед мөрдөгдөж байгаа жижиглэнгийн үнээр зөвхөн шатахуун олгуулна.
- 2.5. Карт эзэмшигч картаа хаяж үрэгдүүлсэн тохиолдолд Картаар үйлчлэгчид хандан картын нөхөн төлбөрийг төлөн дахин сэргээлгэж авна.
- 2.6. Карт эзэмшигч худалдан авах шатахууны өдөр (долоо хоног, сар)-т хийгдэх гүйлгээний тоо болон мөнгөн дүнгээр хязгаарлалт тогтоох боломжтой.
- 2.7. ШТС-д картаар шатахуун худалдан авсан анхан шатны баримтыг 2 хувь үйлдэж, нэг хувийг Карт эзэмшигчид, 2 дахь хувийг Картаар үйлчлэгч гүйлгээ хийгдсэн өдрөөс хойш 3 сарын хугацаанд хадгална.

### ГУРАВ. КАРТААР ҮЙЛЧЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Картаар үйлчлэгч дараахь үүрэгтэй байна:
  - 3.1.1. Карт эзэмших захиалгыг хүлээн авч Гэрээ байгуулан карт олгох,
  - 3.1.2. Гэрээнд бүртгэгдсэн утас, и-мэйл хаягаар нэмэлт мэдээлэл өгөх,
  - 3.1.3. Карт эзэмшигчийн нээлгэсэн ерөнхий болон картын дансанд мөнгө байгаа тохиолдолд Карт эзэмшигч картын үйлчилгээ нэвтрээгүй ШТС-аар үйлчлүүлэх үед Картаар үйлчлэгчийн ахлах менежерийн олгосон зөвшөөрлийн дагуу шатахуун олгож болно. (Энэхүү заалт нь зөвхөн орон нутгийн ШТС-уудад хамаарах ба зайлшгүй тохиолдолд хэрэгжинэ.)
  - 3.1.4. Карт эзэмшигч болон картын талаар холбогдох мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд чандлан хадгалах
- 3.2. Картаар үйлчлэгч дараахь эрхтэй байна:
  - 3.2.1. Карт эзэмшигчээс шатахууны төлбөрийг шаардах эрхтэй.

## ДӨРӨВ. КАРТ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Карт эзэмшигч дараахь эрхтэй байна:
- 4.1.1 Энэхүү гэрээний дагуу ШТС-уудаас шатахууны картаар үйлчилгээ авах,
  - 4.1.2 Худалдан авсан шатахууны хэрэглээний 1 жилийн доторх хугацааны тайланг карт бүрээр дэлгэрэнгүй болон нэгтгэсэн хэлбэрээр бичгээр, и-мэйлээр болон хэрэглэгчид зориулсан вэб хуудсаар авах,
  - 4.1.3 Картын үлдэгдэлээ Инфо үйлчилгээгээр шалгах,
  - 4.1.4 Ерөнхий данс болон картанд орлого орох үед мэссэжээр мэдээлэл авах,
- 4.2 Карт эзэмшигч дараахь үүрэгтэй байна:
- 4.2.1 Карт эзэмшигч байгууллагаас энэхүү Гэрээний Хавсралт 2-д заасан загварын дагуу итгэмжлэлээр код авсан ажилтан интернэтээр картаа цэнэглэх, хаяж үрэгдүүлсэн картыг хаах, худалдан авалтын хязгаарлалт тогтоох, өөрчлөх зэрэг үйлчилгээг хийх ба интернэт кодыг сольж нууцлалаа баталгаажуулах,
  - 4.2.2 Карт эзэмшигч нь өөрийн ажилтан, Жолооч нарт картаа хаяж үрэгдүүлсэн тохиолдолд нэн даруй өөрийн байгууллагын нягтланд хандах эсвэл өөрөө картын төвд хандан картын төлвийг хаалгаж, гуравдагч этгээд ашиглах боломжгүй болгуулах талаар мэдээллийг бүрэн өгөх,
  - 4.2.3 Карт эзэмшигч дараах тохиолдолд Картаар үйлчлэгчид албан бичгээр хандах үүрэгтэй. Үүнд:
    - a) Шинэ карт авах
    - b) Хаяж үрэгдүүлсэн болон гэмтээсэн карт дахин сэргээх
    - c) Итгэмжлэгдсэн ажилтанд интернэт үйлчилгээний эрх авах, итгэмжлэгдсэн ажилтан өөрчлөгдсөн бол (итгэмжлэгдсэн ажилтны албан тушаал, овог нэр, утас, и-мэйл хаяг зэрэг мэдээллийг агуулсан байна.) түүний мэдээллийг өөрчлүүлэх,
    - d) Картын төвөөр дамжуулан карт цэнэглэх, картын лимитийн өөрчлөлт хийх, лимит цуцлах
    - e) Картыг бусдад шилжүүлэх
  - 4.2.4 Тооцоо нийлсэн актыг улиралд нэг удаа баталгаажуулах,
  - 4.2.5 Картын үлдэгдэл болон гүйлгээний хуулгаа тогтмол хянан шалгаж байх,
  - 4.2.6 Энэхүү гэрээний Хавсралт 2-д заасан Карт ашиглах зааврыг карт эзэмшигч жолооч нэг бүрт танилцуулах,
  - 4.2.7 Карт эзэмшигч нь картын пластик, картын дугаар, хүчинтэй хугацаа, нууц код (PIN code) зэрэг мэдээллийг бусдад дамжуулахгүй байх, алдахаас хамгаалах үүрэгтэй. Алдагдсан гэж үзвэл нэн даруй солих,
  - 4.2.8 Карт эзэмшигч гар утасны дугаараа ерөнхий данс, картанд холбуулсан тохиолдолд ерөнхий дансанд орлого орох үед эрх бүхий ажилтны гар утсанд, картанд орлого орох үед карт эзэмшигчийн утсанд энэ тухай мэдээлэл очих ба эзэмшигч этгээд солигдсон тохиолдол бүрт утасны дугаарыг өөрчлүүлэх
  - 4.2.9 Энэхүү гэрээний хүрээнд Карт эзэмшигчээс Картаар үйлчлэгчид төлбөл зохих бүх төлбөр, гэрээний үүргийн зөрчилтэй холбоотой алданги, хохирол, зардлыг үл маргах журмаар Картаар үйлчлэгчид төлж барагдуулна.

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 5.1 Энэхүү гэрээ нь Талууд гэрээнд заасан нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч, эрх бүхий этгээд гарын үзэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 5.2 Гэрээний 6 дугаар зүйлд заасан нөхцөл үүссэн тохиолдолд гэрээг дуусгавар болсонд тооцох ба Карт эзэмшигчийн карт хүчингүй болно.

## ЗУРГАА. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 6.1 Дараахь нөхцөлүүдэд гэрээг цуцална. Үүнд:
  - 6.1.1 Талууд гэрээг цуцлах талаар албан ёсоор харилцан тохиролцсон;
  - 6.1.2 Аль нэг тал гэрээний үүргээ биелүүлээгүй бол энэ талаар нөгөө талд мэдэгдсэнээс хойш ажлын 7 (долоо) хоногийн дараа;
  - 6.1.3 Аль нэг талаас гэрээг цуцлах хүсэлтээ бичгээр хуанлийн 7 (долоо) хоногийн өмнө гэрээг цуцлах үндэслэлийн хамт хүргүүлсэн.

## ДОЛОО. ХАРИУЦЛАГА

- 7.1 Карт эзэмшигчийн картын нууц код (PIN), интернэт үйлчилгээний код алдагдсанаас үүсэх

- 7.2 Энэхүү гэрээний 4.2.2 болон 4.2.7-д заасан үүргээ биелүүлдэггүй, хугацаа алдаж биелүүлснээс болж гуравдагч этгээд картыг ашиглах тохиолдолд үүсэх хохирлыг Карт эзэмшигч бүрэн хариуцна.
- 7.3 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас (цахилгаан, импортын хязгаарлалт, бүтээгдэхүүний хомсдол, холбоо болон шугам сүлжээний доголдол ... гэх мэт) аль нэг тал үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд энэ талаар протокол үйлдэх ба аль нэг тал хариуцлага хүлээхгүй.
- 7.4 Хэрэглэгч карт цэнэглэх шатахууны төлбөрөө банкны салбар, тооцооны төвүүдээр дамжуулан төлөх тохиолдолд гүйлгээний утганд картын дугаарыг бичих бөгөөд хэрэглэгч картын дугаараа буруу бичсэн, мэдэхгүй байх зэрэг тохиолдлоос үүсэх үр дагаврыг картаар үйлчлэгч хариуцахгүй.

#### НАЙМ. БУСАД

- 8.1 Гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөрт тооцогдоно.
- 8.2 Талууд карт ашиглан хийсэн гүйлгээний цахим, цаасан баримт болон тэдгээрийн хуулбарууд мөн гүйлгээтэй холбоотой бусад баримт бичгүүдийг маргаан шийдэх үед нотлох баримт гэж хүлээн зөвшөөрнө.
- 8.3 Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр энэхүү Гэрээ хийгдсэн журмаар хийх ба уг өөрчлөлт болон Хавсралт нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна.
- 8.4 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэх ба ингэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 8.5 Гэрээ сунгалт: Энэхүү гэрээ .....оны..... сарын..... өдрөөс..... оны..... сарын ..... өдөр хүртэл сунгав.


#### ЕС. ТАЛУУДЫН ХУУЛЬ ЁСНЫ ХАЯГ

“Петростар” ХХК  
 “Петровис” ХХК-ийн төв байр,  
 Сүхбаатар дүүрэг,  
 Ерөнхий сайд Амарын гудамж-8  
 Улаанбаатар хот

Утас: 70110808, 11-310931  
 Факс: 11-330808  
 И-мэйл: cardcenter@petrovvis.mn

ХААН Банк - 5038058532 /₮/  
 ХХБанк - 429000747 /₮/  
 Голомт банк - 8115100989 /₮/  
 Төрийн банк - 343100204768 /₮/  
 Хас банк - 5002009938 /₮/

Гэрээ байгуулсан:

Картаар үйлчлэгчийг төлөөлж:  
 “Петростар” ХХК-ийн Картын Албаны  
 Ерөнхий менежер  
  
 П.Сүхбаатар

“Петростар” ХХК-ийн Картын Албаны  
 Ахлах менежер

Б.Энхтуяа



“Радио Телевизийн ҮС” УТҮГ  
 Баянгол дүүрэг, 17-р  
 хороо

Утас: 11-75112020, 88881146  
 Факс: .....

И-мэйл enkhgerel.e@rtbn.gov.mn

Карт эзэмшигчийг төлөөлж:  
 Хангамжийн хэлтсийн дарга

  
 Э.Энхгэрэл

2021 оны .... сарын ....-ны өдрийн ..... тоот гэрээний

Хавсралт I АД  
ХХК

## КАРТ АШИГЛАХ ЗААВАР

Байгууллагын хүсэлтээр карт дээр картын дугаарыг товойлгон шивүүлж болох ба энэ тохиолдолд зөвхөн тухайн дугаар бүхий автомашинд шатахуун олгоно.

### Нууцлал

- Пин код: картаар гүйлгээ хийхэд ашиглагдах дөрвөн оронтой нууц дугаарыг хэлнэ.
- Пин кодыг 3 удаа буруу оруулбал пин код блоклогдоно. Энэ тохиолдолд Картаар үйлчлэгч байгууллагад хандаж пин кодыг сэргээлгэнэ. (утсаар болон и-мэйлээр)
- Карт эзэмшигч картын дугаар, Пин кодыг бусдад дамжуулахгүй зөвхөн өөрөө хэрэглэнэ.

### Карт ашиглалтын горим

- Карт ашиглалтын горимыг зөрчиж болохгүй. Үүнд: Картын пластикийг мушгих, нугалах, хугалах, норгох, хүчтэй соронзон орны нөлөөнд оруулах, хүчил уусгагч бодисоос хол байлгах гэх мэт. Горим зөрчигдөөгүй тохиолдолд картын ашиглагдах хугацаа 5-10 жил байна.
- Карт эзэмшигч нь картыг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан, ажлаас халагдсан ажилтан авч явсан, гэмтээсэн тохиолдолд Интернет үйлчилгээний эрх авсан ажилтан тухайн картыг хааж идэвхигүй төлөвт оруулна. Хэрэв карт эзэмшигч байгууллагын эрх бүхий ажилтан картыг хаах боломжгүй нөхцөлд байгаа бол картыг хаах тухай ажлын цагаар Картаар үйлчлэгч байгууллагад мэдэгдэж картыг хаалгана.
- Карт эзэмшигч байгууллага картыг сэргээж дахин гаргуулах хүсэлт гаргасан тохиолдолд хүсэлт гаргаснаар хойш 24 цагийн дараа Картаар үйлчлэгч байгууллага хуучин картын үлдэгдэл бүхий шинэ картыг бэлэн болгож өгнө.

### Интернэт үйлчилгээ авахад анхаарах зүйлс:

1. **Хэрэглэгчийн дугаар ба нууц үгтэй холбоотой зөвлөгөө:**
  - 1.1. Картаар үйлчлэгчид бүртгүүлсэн И-мэйл хаягаас хүсэлт явуулж Нууц үгээ 1-ээс 2 сар болоод тогтмол сольж хэвших хэрэгтэй. Мөн бусдад алдсан байж болзошгүй тохиолдолд нэн даруй сольж байх.
  - 1.2. Интернет үйлчилгээний нэвтрэх нэр, нууц үгийнхээ талаар хэзээ ч, хэн д ч бүү хэлээрэй. Мөн нууц үгээ ямар нэг цаас, утсан дээрээ хамгаалалтгүй тэмдэглэх хэрэггүй.
  - 1.3. Нууц үгэндээ өөртэйгөө холбоотой он сар өдөр, утасны дугаар, нэр, дансны дугаар болон бусад хувийн мэдээллээ бүү ашигла.
  - 1.4. Өөрийн и-мэйл хаяг, олон нийтийн сүлжээ болон бусад зүйлд ашигладаг хэрэглэгчийн нэр, нууц үгээ интернет үйлчилгээндээ ашиглах хэрэггүй.
  - 1.5. Интернет үйлчилгээний нэвтрэх нэр, нууц үгээ интернет веб хөтөч дээрээ хадгалах хэрэггүй.
2. **Ерөнхий аюулгүй байдлын зөвлөгөө**
  - 2.1. Эрх бүхий этгээд интенет үйлчилгээнд нэвтрэх нэр, нууц үгээ бусдад дамжуулахгүй зөвхөн өөрөө ашиглах,
  - 2.2. Ерөнхий дансны үлдэгдэл, дансны хуулга зэргийг тогтмол хянаж шалгаж байх хэрэгтэй. Хэрэв сэжигтэй зүйл илэрвэл нэн даруй Картаар үйлчлэгч байгууллагад мэдэгдэх хэрэгтэй.
  - 2.3. Интернет үйлчилгээнд нэвтэрсэн үедээ компьютерээ хараа хяналтгүй хэзээ ч битгий орхиорой.
  - 2.4. Интернет үйлчилгээг ашиглаж дуусаад заавал ГАРАХ товчийг дарж холболтоо салгах.

Web: [www.petrovis.mn/card](http://www.petrovis.mn/card)

Нэвтрэх нэр:

Нууц үг:

## НЭР ТОМБЕОНЫ ТАЙЛБАР

“Ерөнхий данс” гэж Карт эзэмшигч байгууллагын Петровис Картын төвд нээлгэсэн шатахуун зарцуулалтын дансыг хэлэх бөгөөд уг дансны дор шатахууны картууд байна.

“Карт цэнэглэлт” гэж картыг мөнгөжүүлэх үйлдэл. Карт эзэмшигч өөрийн биеэр картын төвд ирж картаа цэнэглэх боломжтой. Мөн тодорхой нэр заасан ШТС-уудад ПОС терминал төхөөрөмж ашиглан картаа цэнэглэх боломжтой. Энэ тохиолдолд карт биетээрээ байх ёстой.

“Алсын цэнэглэлт” гэж Картгүйгээр картыг цэнэглэх тохиолдолд Петровис карт ХХК-ны банк дахь дансанд мөнгө байршуулж, ерөнхий данснаас карт руу шилжүүлэх үйлдлийг ойлгоно.

- Картын хэрэглэгчийн хүсэлтээр (утсаар, факсаар) картын төвд хүсэлт хүлээн авч хэрэглэгчийн картанд байршуулж хуваарилах эсвэл байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан Интернэт үйлчилгээ ашиглан ерөнхий данснаас картууд руу хуваарилан цэнэглэх боломжтой.

“Үлдэгдэл хүрэлцэхгүй байх” гэж ерөнхий данс болон картыг цэнэглэсэн мөнгө дуусч гүйлгээ хийх боломжгүй байхыг ойлгоно.

“Гүйлгээний хязгаарлалт” гэж гүйлгээ хийх тоо болон мөнгө дүнд хязгаарлалт тавих боломжтой. Хугацааны хувьд : Өдрийн , Долоо хоногийн, Сарын гэж гүйлгээний хязгаарлалт байж болно.

- Өдрийн хязгаарлалт: Нэг өдөрт хийх гүйлгээний тоо болон мөнгөн дүнг илэрхийлнэ.
- Долоо хоногийн хязгаарлалт: Календарийн нэг долоо хоногийн хугацаанд хийх гүйлгээний тоо болон мөнгөн дүнг илэрхийлнэ.
- Сарын хязгаарлалт: Календарийн нэг сарын хугацаанд хийх гүйлгээний тоо болон мөнгөн дүнг илэрхийлнэ.

“Гүйлгээний хязгаарлалт өөрчлөх” Картаар үйлчлэгч нь тухайн картын хязгаарыг байгууллагын албан тоотын дагуу өөрчлөх эсвэл эрх бүхий ажилтан Интернэт үйлчилгээг ашиглан картанд хязгаарлалт тогтоох өөрчлөх боломжтой байна.

“Интернэт үйлчилгээ” гэж Карт эзэмшигч гүйлгээний дэлгэрэнгүй тайлан авах, ерөнхий данснаас картууд руу мөнгө хуваарилан шилжүүлэх, картын гүйлгээнд хязгаарлалт тогтоох, өөрчлөх, цуцлах, картыг идэвхгүй төлөвт оруулах зэрэг үйлдэл хийхэд зориулан Картаар үйлчлэгч байгууллагаас олгосон үйлчилгээ. Интернэт үйлчилгээгээр зөвхөн сүүлийн нэг жилийн хугацааны тайланг авах боломжтой.

“Инфо үйлчилгээ” гэж тусгай 130360 дугаарт форматын дагуу мессеж илгээн ерөнхий данс болон картын үлдэгдэл авах үйлчилгээ. Мөн ерөнхий данс болон картанд орлого орох бүрт энэ тухай мессежээр мэдээллэх боломжтой.

- Ерөнхий дансны үлдэгдэл шалгах
- Картын үлдэгдэл шалгах
- Ерөнхий данс болон картанд орлого орох бүрт бүртгүүлсэн утасны дугаарт мессежээр мэдээллэх